БАТЛАВ:

ЗАХИРАЛ С.ГАЛБАДРАХ

“СУДЛААЧ ОЮУТАНААС ЧАДВАРЛАГ ИНЖЕНЕР 2025” СЭДЭВТ ОЮУТНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРЛЫН УДИРДАМЖ

НЭГ. ЗОРИЛГО

“Хүн, байгальд ээлтэй инновац технологийг бүтээх инженер судлаачдыг бэлтгэдэг үндэсний хэмжээнд тэргүүлэх, практикт суурилсан мэргэжлийн их сургууль байна.” гэсэн ТЗДС-ийн эрхэм зорилгыг хэрэгжүүлэхийн тулд суралцагчдыг судалгаа, эрдэм шинжилгээний ажилд дадлагажуулах, бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх, багш оюутны хамтын шилдэг судалгааны бүтээлийг шалгаруулан урамшуулах зорилгоор оюутны эрдэм шинжилгээний хурлыг хичээлийн жил бүрийн хаврын улиралд уламжлал болгон зохион байгуулдаг.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

УБТЗ ХНН-ийн сургалтын байгууллагуудын оюутнууд

ГУРАВ. СЭДВИЙН ЧИГЛЭЛ

- ✓ Төмөр замын тээврийн аюулгүй байдал, осол гологдлыг бууруулах
- ✓ Техникийн шинэчлэл, засвар үйлчилгээ
- ✓ Байгаль орчин ба тогтвортой хөгжил (төмөр замын салбарт бохирдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлттэй хөдлөх бүрэлдэхүүний судалгаа, хүлэмжийн хийг багасгах төмөр замын шийдлүүд, нарны эрчим хүч ашиглах боломжит загварууд, байгаль орчинд ээлтэй зүтгүүрийн шинэ загвар)
- ✓ Тээврийн төлөвлөлт, эдийн засаг
- ✓ Дижитал шилжилт, автоматжуулалт
- ✓ Оюутны хөгжил, төлөвшил (Оюутны сэтгэл зүйн тэнцвэрт байдал ба хувь хүний төлөвшил, төлөвшилд эерэг багшийн нөлөө, өөрийгөө үнэлэх үнэлэмж,, итгэлтэй байдал, оюутны ёс зүй, ба нийгмийн хариуцлага, хариуцлага сахилга бат, суралцах дэг журмын уялдаа холбоо, сургуулийн нийгмийн орчин, дижитал орчин ба хувь хүний төлөвшил)

ДӨРӨВ. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛД ТАВИХ ШААРДЛАГА

1. Илтгэл нь хураангуй, түлхүүр үг, оршил, сэдэв сонгосон үндэслэл, үндсэн хэсэг(текст, зураг, хүснэгт) дүгнэлт, ашигласан материал, А-4 хэмжээгээр 5-8 хуудсанд багтсан байна.
2. Илтгэлийг Times New Roman фонтоор 11 pt үсгийн өндрийг сонгож, хуудасны дээд, баруун, зүүн талаас нь 2.5 см, доод талаас нь 3.0 см, мөр хоорондох зай 1 sp байна. Header, Footer, Footnote команд ашиглахгүй, хуудас дугаарлахгүй.

3. Илтгэлийн хураангуйг 15 мөр, 200 үгэнд багтаан бичнэ. Илтгэлд 4-5 түлхүүр үг хэрэглэгдэх ба түлхүүр үг нь нэр үг, нэрлэхийн тийн ялгал, ганц тоо байна. Илтгэлийн нэрэнд орсон үг түлхүүр үгэнд орохгүй.
4. Илтгэлд оруулсан фото зураг, зураг, график нь хар цагаан өнгөтэй, математик бичиглэлүүд Equation программаар мөр голлон бичигдэнэ. Томьёоны дугаарыг тухайн мөрний төгсгөлд бага хаалтад бичнэ.
5. Илтгэлийн нэр, анги, удирдсан багш, холбогдох цахим хаяг, утсыг илтгэлийн эхний нүүрэнд бичнэ.

ТАВ. ИЛТГЭЛИЙГ ШАЛГАРУУЛАХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1. Сонгосон сэдвийн хүрээнд бодит нөхцөл байдал, дэвшүүлж буй шийдлийг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон шинэлэг санаа дэвшүүлсэн байх;
2. Илтгэл нь хураангуй, удиртгал, үндсэн хэсэг, дүгнэлт, иш татсан ном зохиол, бүтээл, судалгаа, эх сурвалжийг тодорхой дурдсан байх;
3. Илтгэлийг ганцаарчилсан болон хамтран бэлтгэж болох ба удирдагч багштай байх;
4. Илтгэл хэлэлцүүлэх шатанд шалгарсан бол PPT хэлбэрээр бэлтгэх ба хугацаа 10 минут, хэлэлцэх хугацаа 5 минут хүртэл байна.

ЗУРГАА. ИЛТГЭЛИЙГ ШАЛГАРУУЛАХ ҮЕ ШАТ

- ✓ Бүтээлийг 2025 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 24.00 цаг хүртэл byambasuren.m@ubtz.mn хаягаар хүлээж авна. Бүтээлийн эхийг Microsoft Word (*.docx) файл хэлбэрээр илгээнэ.

  I шат. 2025 оны 05 сарын 20-23-ны өдөр ажлын комиссын хүрээнд шалгаруулалт явагдаж, өгүүллийн шүүмж, II шатанд тэнцсэн оролцогчдод урилга, хөтөлбөр хүргүүлнэ. Оролцогчид шүүмжийн дагуу засварласан өгүүлэл, II шатанд тэнцсэн оролцогчид “Powerpoint” илтгэлээ 2025.05.28-ны 20:00 цагаас өмнө byambasuren.m@ubtz.mn мэйл хаягаар явуулна.

- ✓ II шат. Шалгарсан өгүүллийг 2025 оны 05 сарын 29-ний өдөр хэлэлцүүлж, шилдэгүүдээ тодруулна.

Оюутны судалгааны ажил нь эмхэтгэл болон хэвлэгдэж, ТЗДС-ийн номын санд байршин судлаачдын хүртээл болох учир удирдагч багш судалгааны өгүүллийн стандартыг хангахад оюутанд зөвлөн тусалж ажиллана.

ДОЛОО. ШАГНАЛ, УРАМШУУЛАЛ

Оюутны судалгааны ажлыг төгсөх курсийн оюутан, 1-3-р курсийн оюутан гэсэн хоёр түвшинд курсийн ялгамжтай дүгнэж, урамшуулна.

1. Тэргүүн байр- 2: Өргөмжлөл, 2 кредитийн төлбөрийн хөнгөлөлт
2. Шагналт байр-7: Өргөмжлөл, 1 кредитийн төлбөрийн хөнгөлөлт

Зохион байгуулагч: Төмөр замын дээд сургуулийн эрдмийн зөвлөл
Утас: 99183426, Э-шуудан: byambasuren.mya@gmail.com, byambasuren.m@ubtz.mn